

20. Хүнсний аюулгүй байдал

83. Улс орны үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг нь хүн амыг чанартай, аюулгүй, хүртээмжтэй хүнсээр хангах бөгөөд төрийн онцгой анхааралд байх асуудал юм. Монгол Улсын Үндсэн хуульд "Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй" гэж заасан. Үндсэн хуульд зохистой, аюулгүй хоол хүнсээр хангагдах эрхийг тусгайлан заагаагүй хэдий ч энэ эрх нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн бүрэлдэхүүн хэсэг юм. Манай улсад хүнсний хангамж, аюулгүй байдалтай холбоотой харилцааг "Хүнсний тухай", "Газрын тухай", "Усны тухай", "Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай", "Улсын хилээр амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналтын тухай", "Тариалангийн тухай", "Ариун цэврийн тухай" зэрэг хуулиудаар зохицуулж байгаа бөгөөд эдгээр хуулиуд нь бүхэлдээ хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулахад чиглэгдэж байгаа юм.

84. Дэлхий дахинд хүнсний хомсдол бий болж, улс орнууд хүнсний баталгаат байдлын бодлого, хөтөлбөртөө өөрчлөлт оруулж байна. Монгол Улсын Засгийн газраас хүн амын хүнсний баталгаат байдлыг хангах чиглэлээр "Хүнсний хангамж аюулгүй байдал, хоол, тэжээл" хөтөлбөрийг 2001 оны 242 дугаар тогтоолоор батлан, хэрэгжүүлж байсан. Энэхүү хөтөлбөрийг Монгол Улсын хүнсний хангамжийн өнөөгийн байдал, хэтийн төлөв, дэлхийн дахинд буй болсон хүнсний хомсдол, үнийн өсөлт болон энэ талаар НҮБ, бусад олон улсын байгууллагаас гаргаж буй шийдвэр, зөвлөмжтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2009 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 32 дугаар тогтоолоор "Хүнсний баталгаат байдал" үндэсний хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлж эхлээд байна.

85. 2006 онд хийсэн хоол тэжээлийн эрсдэлт хүчин зүйлийн судалгаагаар насанд хүрэгчдийн 4,9 хувь нь туранхай, 21,8 хувь нь илүүдэл жинтэй, 9,8 хувь нь таргалдалттай байхад нийгмийн эмзэг бүлэг болох асран хамгаалах хүнгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настан, ядуу өрхийн хүн амд хүнсний хомсдол илүү их байгаа дүн гарсан байна. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас "Нийгмийн эмзэг бүлэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх" дэд хөтөлбөрийг 2008 онд батлан Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2009 оны эхнээс хэрэгжүүлж байна.

86. Монгол Улсын хүнсний баталгаат байдлыг сайжруулахын тулд хүнсний боловсруулах үйлдвэрийн хүч чадлыг нэмэгдүүлэх, тэдгээрт дотоодын хяналтын GMP, HACCP нэвтрүүлэх, баяжуулсан хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, цаашилбал хүн амын орлогын түвшинг нэмэгдүүлж тэдний хоол хүнсний хэрэглээний мэдлэгийг сайжруулах шаардлагатай байна.